



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2018 оны 06 сарын 28 өдөр

Дугаар 4/260.

Улаанбаатар хот

Г Шилэн дансны үйл ажиллагаанд  
шалгалт хийх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор харьяа байгууллагын шилэн дансны үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх зорилгоор ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Ганзориг, Хуулийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Г.Туул, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн

Гишүүд: С.Энхжин, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн

Д.Хэрлэнчимэг, Хуулийн хэлтсийн мэргэжилтэн

Т.Бямбасүрэн, Хөрөнгө, оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. Харьяа байгууллагын дарга, захирал нарын 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдөр хүтэл гаргасан санхүү, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой бүх тушаалыг PDF хэлбэрт оруулан 2018 оны 07 дугаар сарын 03-ны дотор [d.kherlenchimeg@moh.gov.mn](mailto:d.kherlenchimeg@moh.gov.mn) цахим хаягаар ирүүлэхийг үүрэг болгосугай.

3. Ажлын хэсгийг зохион байгуулалтаар хангаж, үр дүнг 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн дотор тайлагнахыг Хуулийн хэлтсийн дарга /М.Ганзориг/-д үүрэг болгосугай.

4. Тогтоосон хугацаанд тушаалаа ирүүлээгүй байгууллагын дарга, захирал нарт хариуцлага тооцох болохыг дурьдсугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн Захиргааны удирдлагын газрын дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ